



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 1/376

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний эзэмшлийг аймгийн Музейд шилжүүлж, хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Л.Батгэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Н.Гэрэлмаа - Музейн захирал

Н.Наранчимэг - Музейн мэргэжилтэн

Т.Өлзий-Орших - Музейн нягтлан бодогч

О.Балжинням - "Шим Ус" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын горим тооцоо, хяналтын инженер

С.Мягмарсүрэн - Ховд хотын захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Л.Ширнэн - Өв соёлын хүрээлэнгийн сахиул

Нарийн бичгийн


дарга: Г.Тунгалаг

- Ховд хотын захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

8400 01 1200

2. Тус ажлыг хууль журмын дагуу хүлээлгэн өгч, цаашдын үйл ажиллагааг ханган, шийдвэр гаргаж ажиллахыг ажлын хэсэг (Б.Баярсүх)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай..



Б.ДҮГЭРЖАВ